



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 4/10

Улаанбаатар хот

Г  
Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17, Хавдар судлалын үндэсний төв болон Японы эрүүл мэнд, шүдний холбоо, Айчи хавдар судлалын төв хоорондын эмнэлгийн тусламж, дэмжлэг үзүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох гадаадын 1 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080043

Эрүүл мэндийн сайдын  
2016 оны 08 сарын 17-өдрийн  
17 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Nomoto Шүжи Shuji Nomoto	Япон	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001614	Элэг цөс, нойр булчирхайн хавдрын мэс засал	Эмчлэх	2016-08-18 2016-08-20 3 хоног